

“Хөх Ган” ХК-ийн 2018 оны 2р улирлын үйл ажиллагааны тайлан

I. ТАЙЛАНГИЙН ЭХНИЙ ХЭСЭГ

1. Үнэт цаас гаргагчийн нэр, оршин суугаа хаяг:

“Хөх Ган Хувьцаат Компани

Хаяг: Хан уул 1-р хороо Чингэсийн өргөн чөлөө 50-р байр 15 давхар

Утас: 70072777

Факс: 70071777

Электрон хаяг: www.khuhgan.mn

Улсын бүртгэлийн дугаар: 9010001075

Регистрын дугаар: 5126142

Үйл ажиллагааны чиглэл: төмрийн үйлдвэр

Хувьцаа эзэмшигчдийн тоо: 936

2. Удирдлагын талаарх мэдээлэл:

№	Овог нэр	Албан тушаал
1	Б.Мөнхтөр	Ерөнхий захирал, ТУЗ-н дарга
2	Д.Мөнхбазар	Гүйцэтгэх захирал

3. Санхүүгийн байдлын талаарх мэдээлэл:

Компанийн 2018 оны орлогын тайлангийн үзүүлэлтээс зэрэгцүүлэн үзвэл:

/сая төгрөгөөр/


Үзүүлэлт	2018-02р улирал
Борлуулалт	
Борлуулалтын өртөг	
Нийт ашиг /алдагдал/	
Борлуулалт маркетингийн зардал	
Ерөнхий ба удирдлагын зардал	14,376.0
Бусад зардал	
Гадаад валютын ханшийн зөрүүний олз/гарз/	-0.1
Бусад ашиг /алдагдал/	
Татвар төлөхийн өмнөх ашиг /алдагдал/	-14,377.8
Орлогын татварын зардал	
Цэвэр ашиг /алдагдал/	

Компанийн 2018 оны хөрөнгө, эх үүсвэрийн тэнцлийн үзүүлэлтээс зэрэгцүүлэн үзвэл:

/сая төгрөгөөр/

Хөрөнгө, өр төлбөрийн үзүүлэлтүүд	2018 он 02
Эргэлтийн хөрөнгө	7,793,099.3
Эргэлтийн бус хөрөнгө	23,088,359.4
Нийт хөрөнгийн дүн	30,881,458.6
Богино хугацаат өр төлбөр	13,868,001.8
Урт хугацаат өр төлбөр	
Эзэмшигчдийн өмчийн дүн	17,013,456.8
Өр төлбөр, эзэмшигчийн өмчийн дүн	30,881,458.6

4. Хувьцаа эзэмшигчдийн талаарах мэдээлэл:



5. Ногдол ашгийн талаарх мэдээлэл:

Монгол улсын компаний тухай хуулийн 46-р зүйлийн 46.5 дахь заалт, компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны 03 сарын 16-ны өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. “Хөх Ган” хувьцаат компани 2017 онд үйл ажиллагаа явуулаагүй тул ногдол ашиг хуваарилахгүй байхаар тогтоосугай.

“Хөх Ган” ХК нь 2018 онд “Компанийн тухай хууль”-ийн 87, 89 дгээр зүйлд заасан их хэмжээний болон сонирхолын зөрчилтэй гэрээ хэлцэл хийгдээгүй болно.

2018.03.16 нд ТУЗ-ийн хурлын дундаж ирц 100 % буюу 9 гишүүний бүрэлдэхүүнтэй хуралдав .

ТУЗ-с гаргасан тогтоол, шийдвэр түүний биелэлтийг СЗХ, МХБ, болон өөрийн компанийн цахим сайтуудаар цахим хэлбэрээр явуулж тайлагнаж ажилласан.

1. Үнэт цаас гаргагчийн гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны тайлан:
Майнай компани нь 2008 онд хувьцаат компани болж одоогийн байдлаар 900гаруй хувьцаа эзэмшигтэй болсон . Тус үйлдвэр нь жилдээ 40,000 тн төмрийн хүдрийн баяжмалыг шууд ангижруулах технологиор боловсоруулж 92-98%-н агуулгатай шууд ангижруулсан төмөр үйлдвэрлэж байна. Тус үйлдвэр нь 2007-2015 он хүртэл 240 гаруй ажилчидтайгаар 3 төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт явуулж ирсэн 2015оны хагас жил хүртэл дан үйлдвэрлэлт нь кокс явуулсан үндсэндээ кокс үйлдвэрлэх боломжтой гэдгийг баталгаажуулсан. Үйлдвэрлэлтийн өртөгт нөлөөллөх гол түүхий эд болох олон газрын нүүрс туршилт явуулж үйлдвэрийн эдийн засгийн хувьд ч аль ойрхон газраас датах боломжтойг суудалж үйлдвэрлэлтийн хүчин чадал болон зөв зохион байгуулалтийн хүчинд өртөг маань өсөлтгүй харин бууралттайгаар явж ирсэн . **2016-2017 онд** Дэлхийн зах зээлд төмрийн үнэ эрс унасан, үүнээс шалтгаалан төмрийн хүдрийн экспорт буурсан, улс орны эдийн засгийн хүндрэл, валютын ханшны өсөлт болон тус үйлдвэрийн үндсэн түүхий эдийг бэлтгэгч Архангай аймаг дахь төмрийн хүдрийн уурхай, баяжмалын үйлдвэр удаан хугацаагаар зогссон зэрэг шалтгааны улмаас 2015 оны хагас жилээс 2017 он дуустал сул зогсолт хийгээд байна.

2018 оны 08сараас бид DRI болон Агломарат үйлдвэрлэх төлөвлөгөөтэй байгаа.

